БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА Ц.УРТНАСАН

# НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хот

| № | Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Шаардагдах хөрөнгө /төг/ | Хариуцах албан тушаалтан | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|
| *Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, нийтийн албан тушаалтныг авлиын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалтыг мерит зарчимд тулгуурлан зохион байгуулах, ёс зүй сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр:* | | | | | | |
| 1 | 4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт болон АТГазраас ирүүлсэн ХАСУМ-ийг хянасан байдлыг үндэслэн төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшигчийг томилох | Жилдээ | Шаардахгүй | ЭБАТ, ахлах мэргэжилтэн | Хуулийн хэрэгжилт хангагдана. |
| | | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын шинэчилсэн мэдүүлгийг хянах, бүртгэх баталгаажуулах, бүртгэл хөтлөх, хадгалах, тайлан мэдээг хуулийн хугацаанд хүргүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулна. | 02 дугаар сарын 15-ны дотор | Шаардахгүй | ЭБАТ, ахлах мэргэжилтэн | Хуулийн хэрэгжилт хангагдана. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянасан дүгнэлт, ТАЗ-өөс баталсан албан тушаалын тодорхойлолтыг олон нийтэд ил тод, нээлттэй болгоно. | Жилдээ | Шаардахгүй | ЭБАТ, ахлах мэргэжилтэн, Мэдээллийн технологийн хэлтэс | Нээлттэй, ил тод байдлыг хангасан байна. |
| 2 | Нийтийн албанд томилогдох албан тушаалын ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн томилох, дэвшүүлэн томилно. | Жилдээ | Шаардахгүй | ЭБАТ, ахлах мэргэжилтэн | Хууль, журам, болон албан тушаалын тодорхойлолтод тусгагдсаны дагуу төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдсэн байна. |
| 3 | 4.1.1.6. Нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг батлах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх | Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн дүрэм, байгууллагын хэмжээнд мөрдөх Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах . | Жилдээ | Шаардахгүй | Ёс зүйн зөвлөл | Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн ажиллах дүрэм, албан хаагчийн мөрдөх Ёс зүйн дүрэм батлагдсан байна. |
| 4 | 4.1.1.7. нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, | Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, | Жилдээ | Шаардахгүй | Ёс зүйн Зөвлөл, Захиргаа, санхүүгийн хэлтэс | Өргөдөл гомдол мэдээллийг хянан шалгах Ёс зүйн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | хянан шалгах, хариуцлага хүлээлгэх, шийдвэрлэх, албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийг ил тод мэдээлэх | | | | зөвлөл, хяналт шалгалт, дотоод хяналтын хэлтсийн үйл ажиллагааны үр дүн сайжирна. |
| | 4.1.2.6. өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | Иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг дотоод удирдлагын нэгдсэн UB ERP системээр хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж, чанар, үр дүнг сайжруулна. | Жилдээ | Шаардахгүй | Бичиг хэргийн эрхлэгч | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хуулийн хүрээнд шийдвэрлэж, шийдвэрлэлтийн хугацааг багасгах |
| | Авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг цахим хуудас, болон пэйж хуудсаар түгээх, мэдээллийн самбарт байрлуулах | Жилдээ | Шаардахгүй | ЭБАТ, Ахлах мэргэжилтэн, Хуулийн хэлтэс | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. |
| | | АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулах | Жилдээ | Шаардахгүй | ЭБАТ, Ахлах мэргэжилтэн, | |
| | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан | АТГ-аас зохион байгуулах Авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдыг хамруулах | Жилдээ | Шаардахгүй | ЭБАТ, Ахлах мэргэжилтэн, | Авлигаас урьдчилан сэргийлэх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хаагчдыг сургалтад хамруулах | | | | | сургалтуудад бүрэн хамрагдсан байна. |
| *Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшүүлэх чиглэлээр:* | | | | | | |
| 1 | 4.1.2.6. өргөдөл гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | Нийслэлийн нутгийн захиргааны дотоод удирдлагын UB ERP системээр иргэн, ААНБ-ын албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн дагуу түргэн шуурхай шийдвэрлэх; /Нийслэлийн мэдээллийн 1200, 1234 тусгай дугаар, www.ub1200.mn, www.ub1234.mn цахим хуудас/, тайлагнах. | Жилдээ | Шаардахгүй | Бичиг хэргийн эрхлэгч | Иргэд, аж ахуйн нэгжийн санал, хүсэлт, өргөдөл гомдол түргэн, шуурхай шийдвэрлэгдсэн байна. |
| 4 | | Байгууллагын үйл ажиллагааны талаархи мэдээ, мэдээлэл, удирдлагын шийдвэрийг цахим хуудас, мессеж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбар зэргээр дамжуулан иргэдэд мэдээлэх ажлыг тогтмолжуулах | Жилдээ | Шаардахгүй | Захиргаа, санхүүгийн хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс | Мэдээллийн ил тод байдал хангагдана. |
| 5 | | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас төхийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явцын мэдээллийг цахим хуудсанд тогтмол ил тод нээлттэй байршуулах | Жилдээ | Шаардахгүй | Олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн | Мэдээллийн ил тод байдал хангагдана. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг шударга болгох зорилгоор ажил дүгнэх үзүүлэлтийг бий болгох, мэдээлэх | 2-р улирал | Шаардахгүй | Ахлах мэргэжилтэн | Төрийн албан хаагчийн хариуцлага дээшилнэ. |
| *Гурав. Төсөв санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжий үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр:* | | | | | | |
| 1 | 4.1.3.1. улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх | Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд цахим хуудсаар нийтэд ил тод мэдээлэх | Сар бүр | Шаардахгүй | ЭБАТ, Ахлах мэргэжилтэн, Ахлах нягтлан бодогч, ХААХ-ийн хариуцсан мэргэжилтэн | Шилэн дансны тухай хууль хэрэгжинэ. |
| 2 | | Аудитын байгууллагаас төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг Шилэн данс болон байгууллагын цахим хуудсаар олон нийтэд ил тод байршуулах | Жилдээ | Шаардахгүй | Ахлах нягтлан бодогч, Мэдээллийн технологийн хэлтэс | Санхүүгийн ил тод байдал хангагдана. |
| 3 | | Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэх | Жилдээ | Шаардахгүй | Дотоод аудит хариуцсан мэргэжилтэн | Дотоод хяналт шалгалт хэрэгжсэн байна. |
| *Дөрөв. Худалдан авах ажиллагааг шударга, ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр:* | | | | | | |
| 1 | 4.1.4.1.тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх | Худалдан авах ажиллагааны тухайн жилийн төвөлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх | Тухай бүрт | Шаардахгүй | Захиргаа, санхүүгийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны хэлтэс | Худалдан авах ажиллагааны талаархи мэдээлэл нээлттэй болж, иргэд хяналт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тавих нөхцөл бүрдэнэ. |
| 2 | | Эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын урилгыг цахим хуудас болон мэдээллийн хэрэгслээр мэдээлж, тайлагнах | Тухай бүрт | Шаардахгүй | Дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн | Худалдан авах ажиллагааны талаархий мэдээлэл нээлттэй болж, иргэд хяналт тавих нөхцөл бүрдэнэ. |

---ООО---